

ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ – 2

**“Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил”
судалгааны тайлан**

Тайланг боловсруулсан:
Энхбатын Цолмон

Судлаачдын баг:
Алтанхуягийн Алтанбаяр
Төмөрийн Ариунбаяр
Маш-Олдохын Батчимэг
Чогдонтүмэнгийн Жүгдэржамба
Баянмөнхийн Мөнхцэцэг
Орхонхүүгийн Оюун-Эрдэнэ
Төмөрбаатарын Эрхэс
Тогтохбаярын Азбилэг
Бадамцэцэгийн Баясгалан
Энхжаргалын Солонго

Мэдээлэл цуглуулсан баг:
Ганчимэгийн Билгүүн
Гомбосүрэнгийн Цолмон
Рэнцэндоржийн Нарантуяа
Гансүхийн Байгалмаа
Гойтийзын Батцэцэг
Баянжаргалын Цоггэрэл
Бачаагийн Батдаваа
Уранцэцэгийн Ганбаяр
Баярхүүгийн Индрашид
Соёл-Эрдэнийн Нямдэлгэр
Баатарсүрэнгийн Дэлгэрмандах

Хянан тохиолдуулсан баг:
Энхбатын Цолмон
Сюзан Вильсон

Хэвлэлийн эхийг бэлтгэсэн:
Хорлоогийн Балдандорж

Шведийн Хүүхдийг Ивээх Сангийн Нөлөөлөл, Мэдээллэл Харилцааны менежер Барбара Вуурс
Австралийн Тусламжийн Хөтөлбөрийн мэргэжилтэн Лаура МакКеена нарт талархал илэрхийлье.

Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөр | Төв шуудангийн хайрцаг 1023, Улаанбаатар-13, Монгол
Улс | Утас: +976-11-329371, 329365 | Факс: +976-11-329361 |
Цахим шуудан: Mongolia.secretary@savethechildren.org |

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны тайлангуудыг Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь
хөтөлбөр, тус газрын дэргэдэх Хүүхэд хамгааллын аргазүйн төвөөс болон цахим хэлбэрээр
www.savethechildren.mn; <https://resourcecentre.savethechildren.net/> вэб хуудсаас авах боломжтой.

ӨМНӨХ ҮГ

Хүүхдийг Ивээх Сангаас 2016-2017 онд 1,236 сурагчийг хамруулан хийсэн “Өсвөр үеийнхний дуу хоолой-1” судалгаанд оролцсон хүүхдүүд боловсрол, сургуультай холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлж, нөлөөлөх хүсэлтэй байсан бөгөөд бүлгийн ярилцлагуудын үеэр хүүхдүүд сургуулийн орчин дахь шударга бус байдлын талаар санаа зовж байгаагаа илэрхийлсэн байдаг.

Боловсролын орчин дахь шударга байдлын асуудал нь нийгэм дэх тэгш шударга байдлыг хангахад чиглэсэн хүчин чармайлт, үнэт зүйлсийг хөндөж буй онцгой анхаарал хандуулах сэдэв юм. Өсвөр насныхны тэгш гараа, боломжийн талаарх ойлголт, байр суурийг сонсох нь шударга байдлыг дэмжих, сайжруулахад чухал ач холбогдолтой тул Хүүхдийг Ивээх Сан нь өсвөр үеийнхний төлөөлөл болон Транспаренси Интернэйшнл байгууллагатай хамтран “Өсвөр үеийнхний дуу хоолой – 2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгааг 2017-2018 онд гүйцэтгэв. Тус судалгаанд нийслэл Улаанбаатар хот болон Архангай, Өвөрхангай, Дорнод, Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын сургуулиудын 6, 8, 10-р ангийн нийт 2,191 сурагчид, мөн хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн сургуулийн сурагчид оролцсоныг дурдахад таатай байна.

Хүүхдийн эрхийн тухай Конвенцын 12-р зүйлийн дагуу хүүхэд нас, хөгжлийн онцлогтоо тохируулан өөрсдөд нь хамааралтай бүхий л асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх эрхтэй бөгөөд хүүхдэд хамаатай шийдвэр гаргахад түүний санал ихээхэн ач холбогдолтой. Монгол Улсын нийт хүн амын 37.8% нь 19 хүртэлх насны хүүхдүүд байгаа бөгөөд үүний 38.7%-ийг 10-19 хүртэлх насны өсвөр насныхан эзэлж байна. Тус улсад хүүхдийн эрхийн хэрэгжилтэд зарим ахиц гарч байгаа хэдий ч үүрэг хүлээгчдийн хувьд хийж, хэрэгжүүлэх ажил тун их байгааг “Өсвөр үеийнхний дуу хоолой-2” судалгааны үр дүн харуулж байна.

Хүүхдийг Ивээх Сан нь хүүхдийн мэдлэг, хандлага, тэдний дуу хоолой, эрхийн хэрэгжилтийн нөхцөл байдлыг харуулсан “Өсвөр үеийнхний дуу хоолой-2” судалгааны цаг үеийн, бодит, үнэ цэнэтэй мэдээллийг улс төрчид, шийдвэр гаргагчид, багш сурган хүмүүжүүлэгчид, эцэг эхчүүд болон бусад оролцогч талтай хуваалцаж байна.

Хүүхдийн сурч боловсрох эрхийг хангах үүргээ чанартай, нэр төртэй, ёсзүйтэй биелүүлж яваа Монгол улсын мянга мянган багш нарыг хүндэтгэн талархал илэрхийлье!

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаанд оролцсон бүх хүүхдэд, судлаачаар оролцсон “Өсвөр үеийнхний дуу хоолой” бүлгийн оюутнууд, залуустаа тун их талархаж байгаагаа илэрхийлье. Төслийг санхүүжүүлж аргазүйгээр дэмжсэн Шведийн Хүүхдийг Ивээх Санд талархал илэрхийлье. Судалгааны асуумжийг боловсруулалцан, Говьсүмбэр аймагт хамтран ажилласан Транспаренси Интернэйшнл байгууллагад талархал илэрхийлье.

Түүнчлэн, энэхүү судалгааг хийхэд тусалсан ерөнхий боловсролын сургуулиудын захирал, багш нар, фокус бүлгийн ярилцлагад оролцсон бүх хүмүүст талархал илэрхийлье.

Мицуаки Тоёода
Хүүхдийг Ивээх Сангийн Монгол дахь хөтөлбөрийн захирал

Энхбатын Цолмон
Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхдийн Эрхийн
Засаглал хөтөлбөрийн зохицуулагч



Хүний эрхийн түгээмэл тунхаглалд

“Боловсрол нь хүний үндсэн эрх төдийгүй бусад эрхээ эдлэх суурь болдог” гэж хүлээн зөвшөөрсөн.



Тогтвортой хөгжлийн зорилгын

4с хэсэгт “Багш бол хүн төрөлхтний 2030 он хүртэлх боловсролын зорилгоо амжилттай биелүүлэхэд хүргэх гол түлхүүр” хэмээн тэмдэглэсэн.



Хүүхдийн эрхийн тухай конвенцид

Хүүхдэд суурь боловсролыг олгох үйл явц нь ялгаварлан гадуурхалт, хүүхдийн эсрэг бүх төрлийн хүчирхийлэл, дарамтаас ангид явагдах ёстойг заасан.

Боловсрол бол мэдлэг, ур чадвар, үнэт зүйлс, итгэл үнэмшил, зөв хэвшлийг сурах үйл явц, мөн түүний үр дүн юм. Гэвч ялгаварлан гадуурхалт, авлига, ашиг сонирхлын зөрчил, багш, ажилтнууд, насанд хүрэгчдийн зүгээс үзүүлж буй зохисгүй үлгэрлэл зэрэг нь боловсролын үндсэн зорилгыг гажуудуулж, сурах эрхээ эдлэхэд нь саад учруулж, хүүхдийн төлөвшилд сөргөөр нөлөөлөх хүчин зүйл болсоор байна.



Боловсролын талаар алагчлахтай тэмцэх тухай 1960 оны конвенцид

Хүүхдийг элдвээр ялгаварлах, онцлох, хязгаарлах буюу давуу тал олгохыг илэрхийлэхийг хориглосон бөгөөд тус конвенцийн “боловсрол” гэсэн нэр томъёонд боловсрол эзэмших боломж, сургалтын түвшин, чанар, суралцах нөхцөл зэргийг хамааруулж ойлгохыг заасан.

Оролцогч улсууд хүүхдийн, түүний эцэг, эх буюу хууль ёсны асран хамгаалагчийг арьс үндэс, арьсны өнгө, хүйс, хэл, шашин, улс төрийн болон бусад үзэл бодол, үндэс, угсаа, нийгмийн гарал, эд хөрөнгө, эрүүл мэнд, төрсөн болон бусад байдлаас шалтгаалан аливаа хэлбэрээр алагчлахгүй энэхүү Конвенцид заасан бүх эрхийг харьяалалдаа байгаа хүүхэд бүрийн хувьд хүндэтгэн хангана.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 2-р зүйл

Боловсрол хүүхдийг амьдрах ухааны чадвартай болгох, хүний эрхийг бүрэн дүүрэн эдлэх боломжийг нь бүрдүүлж, хүний эрхийн мөн чанарт нийцсэн соёлыг хөгжүүлэхүйц байдлаар эзэмшигдэх ёстой.

Боловсролын зорилго нь хүүхдийн чадвар, суралцахуйн чадамж, бие хүний эрхэм чанар, өөрийн үнэлэмж, өөртөө итгэх итгэлийг хөгжүүлэхэд оршино.

НҮБ-ын Хүүхдийн эрхийн тухай конвенцийн 29-р зүйлийн “Боловсролын зорилгын тухай” 2001 оны Ерөнхий тайлбараас

АГУУЛГА

Өмнөх үг	3
“Өсвөр үеийнхний дуу хоолой-2” судалгаа гэж юу вэ?	7
Бид энэ судалгаагаар юунд зорьж байна вэ?	7
Судалгааны үр дүнгийн хураангуй	8
Судалгааг хэрхэн хийсэн бэ?	11
Судалгааны бүлэглэсэн үр дүн	13
1. Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх хүүхдүүдийн хандлага, ойлголт, мэдээлэл	14
2. Сургуулийн орчин дахь шударга бус байдал, авлига, ашиг сонирхлын зөрчил	22
3. Шударга бус байдал, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл зориг	31
4. Шударга байдал ба орчны нөлөө	33
Хавсралт	35



“Шударга бай гэж биднээс шаардаж байгаа насанд хүрэгчид өөрсдөө хэрхэн шударга бус байхыг үг болон үйлдлээрээ харуулаад байхаар бид тэгээд шударга байхыг хэнээс сурах вэ?”

А, 15 настай, эмэгтэй

Хүүхдүүдийн

95.9%

нь авлига ашиг сонирхлын зөрчил нь буруу зүйл гэж үзсэн байна.

Хүүхдүүдийн

72.6%

нь шударга ёсыг цогцлоох, авлигатай тэмцэхэд хүүхэд залуус үүрэг гүйцэтгэж чадна гэсэн нь урамтай байлаа.

“ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ – 2” СУДАЛГАА ГЭЖ ЮУ ВЭ?

2016-2017 онд 1,236 сурагчийг хамруулан хийсэн “Өсвөр үеийнхний дуу хоолой-1” судалгаанд оролцсон 3 хүүхэд тутмын 1 нь боловсрол, сургуультай холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлж, нөлөөлөх хүсэлтэй байсан юм. Хүүхдүүдийн 53.4% нь сургуулийн орчинд “бусад шалтгаанаар” дарамт хүчирхийлэлд өртсөн гэсэн дүн гарсан нь бидний анхаарлын татсан юм. Судалгааны энэ дүнгээс нарийн мэдээлэл харах боломжгүй байсан ч бүлгийн ярилцлагуудын үеэр хүүхдүүд багшийн зүгээс өөрийн үзэмжээр хүүхдэд хандах, тал тохой татах байдал, удаа дараагийн ялгаварлан гадуурхалтын хохирогч болсон, үүний улмаас сэтгэл санаа тавгүй байсан тухайгаа илэрхийлсэн билээ. Энэ нь Хүүхдийг Ивээх Сан ба “Өсвөр үеийнхний дуу хоолой” бүлгийг сургуулийн орчинд хүүхдүүд хэрхэн ялгаварлан гадуурхагдаж байгааг, насанд хүрэгчдийн үйлдэл нь хүүхдийн ёсзүй, итгэл үнэмшил бүрэлдэн тогтоход хэрхэн нөлөөлж байгааг судлахад хүргэлээ.

Олон улсад Транспаренси Интернэйшнл байгууллагаас хийдэг “Хүүхдийн шударга байдлын судалгаа”-ны асуумжийг 2017-2018 онд хийсэн “Өсвөр үеийнхний дуу хоолой – 2: Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчил” судалгаанд тохируулан ашиглалаа.

БИД ЭНЭ СУДАЛГААГААР ЮУНД ЗОРЬЖ БАЙНА ВЭ?

“Өсвөр үеийнхний дуу хоолой-2” судалгаа нь хүүхдүүд сурах эрхээ хэрхэн эдэлж, эрхийг нь хэрхэн хүндэтгэн хэрэгжүүлж буй талаарх тэдний сэтгэгдэлийг мөн, тэднийг сурах эрхээ эдлэхэд нь саад учруулж буй асуудлуудаар нарийвчилсан мэдээллийг илрүүлж, энэ хүрээнд шинэ мэдээлэл, мэдлэгийг тодруулав.

Энэхүү мэдлэгийг хүүхдүүдийн амьдралд шийдвэрлэх нөлөөтэй насанд хүрэгчдэд хүргэхийг бид зорьж байгаа юм. Багш эцэг эхчүүд, насанд хүрэгчид энэхүү мэдлэгийг чин сэтгэлээсээ ойлгож, сургуулийн орчинд шударга байдлыг тогтооход хүүхдийн оролцоог дэмжин тэдэнтэй хамтран ажиллаасай гэж байна.



Багш нар хоорондоо “Манай тэр хүүхдийн дүнг гайгүй гаргахын бодоорой” гэж ярилцдаг. Оронд нь тэр багш бас нэг юмаар тусалдаг. Багш нарын ажлыг сурагчдын дүн хэр гарснаас нь дүгнэх нь өрөөсгөл. Илүү үнэлгээтэй болох гэж багш нар хоорондоо тохирцгоодог.

С, 16 настай, эмэгтэй

Судалгаанд хамрагдсан нийт хүүхдийн 70 гаруй хувь нь үргэлж шударга байх боломжгүй гэж үзсэн бол нийт судлуулагчдын 43% нь худал хэлдэг хууран мэхэлдэг хүмүүс шударга хүмүүсээс илүү сайхан амьдардаг гэж ойлгосон байгаа нь бидний санааг зовоож байна.


Үүний зэрэгцээ, фокус бүлгийн ярилцлагад хамрагдсан хүүхдүүдийн 88% нь сурагчийн мэдлэгийг дүнгээр, багшийн ажлын амжилтыг сурагчдын дүнгийн үзүүлэлтээр хэмждэг тул сурагчид онц сурдаг хүүхдүүдэд мөнгө өгч даалгавраа хийлгэх явдал мөн багшийн ажлыг амжуулж тусалж дүн авах байдал их болсон гэж ярьсан нь анхаарал татаж байв.

Эцэст нь, хүүхдийн амьдралыг сайжруулах, тулгамдаж буй чиглэлүүдэд хөрөнгө зарцуулах боломжийг бүрдүүлэх хууль, бодлого, хөтөлбөрийг бий болгох, сайжруулах зорилгоор энэхүү судалгааны үр дүнг ашиглахыг Хүүхдийг Ивээх Сан хүсэж байна.


“ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ-2” СУДАЛГААНЫ ҮР ДҮНГИЙН ХУРААНГУЙ




Хүүхдүүдийн хувьд шударга байдал гэж худал хэлдэггүй, хууль дүрэм мөрддөг, авлига авч өгөхгүй байхыг ойлгодог байна. Харин өөрийн ажлыг бүтээх тохиолдол ирэхэд тухайн асуудлаа шийдэхийн тулд ямар ч арга хамаагүй ашиглана гэсэн нь анхаарал татаж буй асуудлын нэг юм.




Хоёр хүүхэд тутмын нэг нь хэзээ ч худал хэлж хууран мэхэлдэггүй, итгэж болох хүнийг шударга хүн гэж үзэж байна.




Шударга ёсыг сахихгүй байх нь Монгол орны хөгжлийн хувьд аюултай гэж хүүхдүүдийн 72.0% нь үзсэн нь хахууль, авлига авах нь гэр бүл, найз нөхөд, бизнес эдийн засагт цаашлаад Монгол орныг хөгжихөд саад учруулдаг талаар тодорхой ойлголт, төсөөлөлтэй байгаа нь харагдаж байна.



Шударга байх нь баян байхаас чухал ч гэсэн үргэлж шударга байх боломжгүй байна гэж хүүхдүүдийн 72.1% нь үзэж байна.




Худал хэлдэг, хууран мэхэлдэг, хууль зөрчдөг, хахуулийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс бусад хүмүүсээс илүү амжилттай явах талтай байдаг гэж хүүхдүүдийн 43% нь үзэж байна.




Хэн нэгэн ажил, сургуульд ороход нь шалгалтгүйгээр оруулах болбол хүүхдүүдийн 50.2% нь зөвшөөрнө гэжээ.




Сургууль, цэцэрлэгт орох, сурлагын одоогийн түвшнээ зохиомлоор сайжруулах, анги дэвших, сургууль төгсөхөд боловсролын байгууллага, түүний ажилтан, удирдлагад мөнгө өгдөг явдал байна.




Хүүхдүүдийн 21.1% нь гэр бүл нь дүүг нь цэцэрлэгт оруулахын тулд авлига өгсөн гэжээ. 11.9% нь эцэг эх нь сургууль эсвэл цэцэрлэгт шилжүүлэхийн тулд мөнгө өгчээ.



Хүүхдүүдийн 4.8% нь эцэг эх нь өөрийг нь сайн дүн авхуулах эсвэл шалгалтад нь сайн оноо авхуулахын тулд багш эсвэл менежерт бэлэг эсвэл мөнгө өгч байсан гэжээ.




Багш, сургалтын менежерийн хандлагыг өөрчлөхийн тулд хүүхдүүдийн 4.6% нь эцэг эх нь багш эсвэл менежерт бэлэг эсвэл мөнгө өгч байсан гэжээ.




5 болон 9-р анги төгсөхөд анги төгсгөлөө гэж хүүхдүүдийн 44.7% нь багш эсвэл менежерт бэлэг эсвэл мөнгө өгч байсан гэжээ.




Багш нар хичээлд хамаарахгүй ном/захиалгын сонин, сэтгүүл, тасалбар болон бусад эд зүйлс авахыг санал болгодог хэвээрээ байгаа бөгөөд хэрэгцээгүй, хүсээгүй зүйл хүчээр худалдан авах нь олон хүүхдэд дарамт учруулдаг байна.




Хүүхдүүдийн 34.4% нь эвгүй, хэцүү санагдах ч гэсэн бусад нь мөнгө авчрах учраас эцсийн дүнд мөнгө хураалгана гэж үзэж байна.




Хүүхдүүдийн 11.9% нь багш авч л гэсэн бол шууд авна гэжээ.



Таагүй санагдах ч татгалзвал багш өөрөөр хандаж магадгүй гэж хүүхдүүдийн 14.6% нь үзжээ. Энэ нь зарим хүүхдэд багш давуу байдал олгодог болохыг харуулж байна.




Хэрэггүй эд таваар авах мөнгөгүй гэж 6.5% нь худалдан авч чадахгүйгээ шууд илэрхийлж чадна гэжээ.




Хүүхдүүдийн 18.1% нь чадахгүйгээ шууд илэрхийлнэ, учир нь багш яаж ч хандсан гэсэн би мөнгө өгмөөргүй байгаа гэж хариулсан нь хүүхдүүд үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлж чадвал өөрчлөлт хийхийг хүсч байгааг харуулж байна.




Багшийн зүгээс сурагчдын хэн нэгэнд нь давуу байдал олгохоос үүдсэн сэтгэлийн зовууртай байх үе олон хүүхдэд тулгарч байжээ:



Хүүхдүүдийн 37.3% нь өөрөө ангийн дарга болохыг хүсэж байгаа ч өөрийнхөө нэрийг дэвшүүлэхээс илүү ангийн даргыг бусад хүүхэд сонгох ёстой гэж боддог гэжээ.




Хүүхдүүдийн 11.9% нь ангийн дарга болохыг хүсэж байгаа ч багшийн хайртай сурагчдын нэг биш гэж өөрийгөө бодно гэснээс үзвэл сурагчдын оролцох эрх, төлөөлөлд хүртэл багш нөлөөлдөг болох нь илэрхий байна.




Хүүхдүүдийн 69.5% нь өнгөрсөн улиралд бусад дээрэлхүүлж доромжлуулсан гэсэн бол нийт хүүхдийн 15.0% нь багшид 5.6% нь сургуулийн ажилтанд дээрэлхүүлж, доромжлуулснаа илэрхийлсэн байна.




Авлигыг мэдээлж, авлигатай тэмцэх хүсэл зоригийн биелэл нь мэдээлэгчийг хамгаалдаггүй тул мэдээлснээр өөрт нь ирэх дарамтаас шалтгаалж, хэрхэн мэдээлэхээ мэдэхгүй байгаагаа хүүхдүүд илтгэлээ.




Хүүхдүүдийн 33.4% нь мэдээлнэ гэсэн бол, 31.4% нь бүх тохиолдлыг бол мэдээлэхгүй, тухайн нөхцөл байдлаас шалтгаалан мэдээлнэ гэжээ.



Хүүхдүүдийн 18.3% нь мэдээллээ гээд ямар ч нэмэргүй, 9.9% нь намайг хамгаалахгүй учраас би мэдээлэхээс айж байна гэсэн бол




Хүүхдүүдийн 8.9% нь өөртөө анхаарал татмааргүй байгаа учраас хэнд ч мэдээлэхийг хүсэхгүй байна гэсэн байна.




Харин 14.0% нь хаашаа хэрхэн мэдээлэхээ мэдэхгүй байна гэжээ.




Хүүхдэд шударга байдлын талаар үзэл бодол төлөвшихөд гэр бүл, сургууль хамгийн чухал нөлөөтэй гэж тэд үзэж байна



Хүүхдүүдийн 81.2% нь шударга ёсыг сахих хэрэгтэйг илэрхийлсэн мэдээллээр хангаж, санаа сэдэл өгч байдаг хүмүүс бол гэр бүлийнхэн мөн үү гэдэг асуултанд тийм гэж хариулжээ.



Шударга ёсыг сахих хэрэгтэйг ойлгуулах газар сургууль байх ёстой юу гэсэн асуултанд Хүүхдүүдийн 68.8% нь тийм гэж хариулжээ.



Харин энэ асуултанд найз нөхөд, үеийнхэн 51.6%, олны танил хүмүүс 35.2%, биенес эдийн засгийн салбар 29.0% нөлөө үзүүлдэг бол хэвлэл мэдээллийнхэн 60.6% нөлөөтэй гэж үзжээ.

“ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ-2” СУДАЛГААГ ХЭРХЭН ХИЙСЭН БЭ?

СУДАЛГААНЫ ЗОРИЛГО

Сургуулийн орчин дахь шударга ёс, авлига, ашиг сонирхлын нөхцөл байдлын талаарх өсвөр насны хүүхдүүдийн ойлголт, хандлага, зан үйл, үзэл бодлыг

- 1 Шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх хүүхдүүдийн хандлага, ойлголт, мэдээлэл
- 2 Сургуулийн орчин дахь шударга бус байдал, авлига, ашиг сонирхлын зөрчил
- 3 Шударга бус байдал, авлига, ашиг сонирхлын зөрчилтэй тэмцэх хүсэл зориг
- 4 Шударга байдал ба орчны нөлөө

зэрэг чиглэлээр тодруулахад энэхүү судалгааны зорилго оршино. Хүүхдийн ирээдүйн амьдралд эерэг нөлөө үзүүлж чадахуйц чанартай боловсролыг тэгш хүртээмжтэйгээр эзэмшүүлэхэд чиглэсэн ажлыг нь сайжруулах зорилгоор судалгааны үр дүнг үүрэг хүлээгчид, шийдвэр гаргагчид бусад өргөн хүрээний хүмүүстэй хуваалцах юм.

СУДАЛГААНЫ АРГА

Судалгааны үндсэн арга нь асуулга байв. Асуулга ерөнхий 23, нарийвчилсан 94 асуулттай. Судалгааг авахдаа сургалт мэдээлэл хийж, судалгаанд хамрагдсан хүүхдүүдээс болон эцэг эхчүүд, багш нараас сонгон ганцаарчилсан болон фокус бүлгийн ярилцлага авлаа. Эдгээр ярилцлагын эшлэлүүдийг судалгааны үр дүнгийн хэсэгт шигтгэлээ. Судалгааны асуулгыг Хүүхдийг Ивээх Сангийн Хүүхдийн Эрхийн Засаглал хөтөлбөртэй Транспаренси Интернэйшнл ОУБ-ын Өсвөр үеийнхний дэмжих хөтөлбөр хамтран боловсруулж, 6,8,10-р ангийн сурагчдад ойлгогдох байдлыг урьдчилан тандаж уншуулж засварласан болно.

СУДАЛГААНД ОРОЛЦОГЧИД:

Судалгаанд тус улсын 3.1 сая хүн амын бараг тал хувь нь оршин суудаг Улаанбаатар хот болон Архангай, Өвөрхангай, Дорнод, Сэлэнгэ, Төв, Говьсүмбэр аймгийн ерөнхий боловсролын сургуулийн 6 (11-12нас), 8 (13-14нас), 10 (15-16нас)-р ангийн 2223 сурагчийг (хөгжлийн бэрхшээлтэй хүүхдүүдийг оролцуулан) хамруулсан. Судалгааны явцад нийслэл хотод зохион байгуулагдсан Хүүхдийн оролцооны үндэсний чуулганд оролцсон 21 аймаг 9 дүүргийн хүүхдүүдийн саналыг бичгээр хүлээн авсан болно. 32 судалгааны бөглөсөн хуудсыг бүрэн бус гэсэн шалтгаанаар хүчингүйд тооцон, нийт 2,191 судалгаанд дүн шинжилгээ хийсэн. Улсын хэмжээнд 6, 8, 10-р ангид нийт 106,177 хүүхэд сурч байгаатай харьцуулан үзвэл судалгаанд хамрагдсан хүүхдүүд тэдгээрийн 2.1%-ийг эзэлж байна.

ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ОРОЛЦОО:

Судалгааны хэрэгцээ шаардлагыг тодорхойлох, асуумж боловсруулалт, байршлыг тодорхойлох, судалгаа авах, мэдээлэл цуглуулах кодлох, “SPSS 23” программд мэдээллийг оруулах, декодлох, дүн шинжилгээ хийх бүх үйл явцад “Өсвөр үеийнхний дуу хоолой” бүлгийн өсвөр үеийнхэн, окутнууд оролцож Хүүхдийг Ивээх Сан, Транспаренси Интернэйшнл байгууллагуудтай хамтран ажиллаа.

СУДАЛГАА ХИЙСЭН ХУГАЦАА, ҮЙЛ ЯВЦ

2018 оны 1-р сар	<ul style="list-style-type: none"> • Төслийн үйл ажиллагааны хүрээг батлав. • Төслийн хүрээнд хамтран ажиллах уулзалтууд хийж эхлэв. • Чадавх бэхжүүлэх сургалтууд хийж эхлэв.
2018 оны 2, 3-р сар	<ul style="list-style-type: none"> • Судалгааны асуумжийг боловсруулав. • Судалгааны асуумжийг боловсруулав
2018 оны 4, 5-р сар	<ul style="list-style-type: none"> • Судалгааны мэдээлэл цуглуулав. • Фокус группын болон ганцаарчилсан ярилцлагууд зохион байгуулав.
2018 оны 6,7,8-р сар	<ul style="list-style-type: none"> • “SPSS-23” програмын сургалт хийв. • Хүүхдээс авсан асуулгыг .. үзүүлэлтээр “SPSS 23” програмд кодлон оруулах, тайлах, дүн шинжилгээ хийх ажлыг гүйцэтгэв.
2018 оны 9-10-р сар	<ul style="list-style-type: none"> • “Уншихад хялбар байх” гэсэн зарчимд үндэслэн судалгааны тайланг боловсруулав. • Орчуулав.

ХЯЗГААРЛАЛ

Судалгааны зорилго, асуулгатай танилцсаны үндсэн дээр сургуулиуд судалгаа авах зөвшөөрөл өгсөн. Ингэх явцад сургууль, багш руу чиглэсэн асуултуудаас сургуулийн зарим удирдлага эмээж, судалгаа хийх зөвшөөрөл өгөхдөө эргэлзэж байсан тул сургуулиудын нэрийг асуултаас хассан болно. Ингэснээр судалгааны үр дүнг сургууль, дүүргээр харьцуулах боломж гараагүй.



Гэртээ бусдыг муу хэлэх, дорд үзэх байдал хүүхдийнхээ дэргэд гаргахаар хүүхэд бусад хүүхдийг тэгэж ялгаварлан гадуурхдаг болдог. Бас багш ялгаварлан гадуурхаж болохгүй гэх мөртлөө өөрөө хүүхдүүдэд ялгаатай ханддаг. Хүүхэд багшаас бас ёсзүйгүй байхыг “сурч байна”

Н, 15 настай эрэгтэй



Томчууд найз нөхөд, ажлын газрынхан, өөр айлын хүн, багш гээд том хүмүүстэй ялгаатай харьцдаг. Харин хамгийн ихээр хайрлах ёстой өөрийнхөө хүүхдийн дэргэд ёсзүйтэй шударга байж чаддаггүй, муухай зангуудаа ичилгүй харуулдаг том хүмүүс олон байдаг. Хүүхдийнхээ дэргэд худал хэлэх, бусдад утсаараа худлаа ярьдаг, бас ажлаа муухай шударга бус аргаар бүтээж байгаагаа ярихыг хүүхэд сонссон л байдаг.

Ц, 15 настай эмэгтэй



Онц сурдаг хүүхдүүд мөнгөөр бие даах ажил энэ тэр хийж өгдөг. Хүүхдүүд нэгнээрээ даалгавараа хийлгээд оронд нь мөнгө өгдөг. Өөрийгөө бас эцэг эхээ хуурч байна. Нэг нь хүнд тусалж чаддаггүй хүн болж, нөгөө нь авлигалаар ажлаа шийддэг хүн л болох байх даа.

С, 15 настай эмэгтэй

“ӨСВӨР ҮЕИЙНХНИЙ ДУУ ХООЛОЙ-2” СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Сургуулийн орчин, гэр бүлийн орчин мөн өнөөгийн нийгэм хүүхдүүдийн шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаарх ойлголт, хандлага, зан байдал цаашлаад тэдний хувь хүн төлөвшилтөд ихээхэн сөргөөр нөлөөлж байгааг бидний судалсан 4 бүлэг асуудлын үр дүн, хүүхдүүдтэй хийсэн ярилцлагууд гэрчилж байна. Улмаар хүүхдүүд өсөн том болох тусмаа шударга ёс, авлига, ашиг сонирхлын зөрчлийн талаар улам илүү эерэг ойлголт, хандлагатай болж байгаагийн сацуу тэд шударга бус зан төлөв гаргах нь нийгмийн хэрэгцээ, шаардлага юм гэх итгэл үнэмшилтэй болох хандлагатай байна.

Шударга байдлыг дэнслэх хүүхдийн ёс суртахуун, зан байдал томчууд биднээс шалтгаалан ийнхүү сөргөөр төлөвшин хөгжиж байгаа нь урт хугацаандаа тааж баршгүй сөрөг үр дагавар, нийгмийн хямралыг бий болгох эрсдэл, аюултай гэж бид үзэж байна. Иймд амьдралд үг, үйлдлээрээ хүүхдэд үлгэр дуурайлал үзүүлдэг насанд хүрэгчид, багш сурган хүмүүжүүлэгчид, боловсролын зорилгыг ахин эргэн санаж, хүн амьдралдаа насан турш биеэ авч явах хэм хэмжээ болсон ёсзүйдээ анхаарч, зөв дуурайлал өгдөг байгаасай гэж Хүүхдийг Ивээх Сан хүсэж байна. Сургуулиуд хүрч болохуйц бодитой зорилт тавьж, багш, сурагчдыг хуурамч амжилтаас татгалзах ажлыг зохион байгуулж, сурган хүмүүжүүлэх үйл явцыг хүчирхийллийн аливаа хэлбэрийг хэрэглэхгүйгээр явуулах багшийн ёсзүйн дүрмийг сурагчид, эцэг эхэд нээлттэй танилцуулж, авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлж, гэнэтийн болон төлөвлөгөөт шалгалтыг явуулж байх хэрэгтэй гэж Хүүхдийг Ивээх Сан хүсэж байна.



Сургуулийн сурагч, багш, ажилтнууд, удирдлагад бүгдэд үйлчилдэг сургуулийн дүрэм журмыг хүүхдүүдийн оролцоотойгоор баталдаг байж, багш, ажилтан удирдлагад хүүхдийн эрх, хүний эрхийн мэдлэг мэдээллээр тогтмол хангадаг байж, хүүхдийг сонсдог ил тод байдлыг хөгжүүлэх шаардлагатай ба үүрэг хүлээгчид болон хүний эрхийн байгууллагуудыг энэ чиглэлд анхаарлаа хандуулаасай гэж Хүүхдийг Ивээх Сан үзэж байна.


1

ШУДАРГА ЁС, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ТАЛААРХ ХҮҮХДҮҮДИЙН ХАНДЛАГА, ОЙЛГОЛТ, МЭДЭЭЛЭЛ

ШУДАРГА ХҮН ГЭЖ ХЭНИЙГ ХЭЛЭХ ВЭ?

Шударга хүн гэж хэзээ ч хууран мэхэлдэггүй тиймээс итгэж болох хүнийг хэлнэ гэж хоёр хүүхэд тутмын нэг нь (49.7%) үзэж байгаа бол судалгаанд оролцсон хүүхдүүдийн 42.8% нь хэзээ ч хууль зөрчиж, авлига авдаггүй хүнийг шударга хүн хэмээн үзсэн нь хүүхдүүд шударга байдлын талаар зөв ойлголт, үзэл хандлагатай байгааг харууллаа. (Асуулт Б1.)

Хүүхдийн хувьд шударга хүн гэж хэзээ ч хууран мэхэлдэггүй тиймээс итгэж болох хүн



Хүүхдийн хувьд гэр бүл, багш нар нь илүү шударга хүмүүст тооцогддог бөгөөд тэднээс үлгэр дуурайлал авч байна. Мөн найз нөхөд, хэвлэл мэдээллээр авч байгаа мэдээлэлдээ үндэслэн даган дуурайх, үлгэрлэх хүнээ бас сонгодог гэсэн хариулт олон байлаа. (Асуулт Б20-Б22).




Найз нөхөд, гэр бүлийнхэн маань миний хувьд хамгийн шударга хүмүүс. Учир нь манай найз надаас хэзээ ч хуулж байгаагүй. Ээж, аав бол намайг алдаа гаргасан бол шударгаар буруугаа хүлээж сурах хэрэгтэй гэж хэлдэг.

О, 12 настай эрэгтэй


БАЯН БАЙХ НЬ ЧУХАЛ УУ, ШУДАРГА БАЙХ НЬ ЧУХАЛ УУ?

Судалгаа авсан нийт хүүхдүүдийн 72.7% нь “баян байх нь хамгийн чухал зүйл биш” гэж хариулсан нь сайшаалтай байгаа хэдий ч 4.2% нь “баян байх нь чухал” хэмээн үзсэн байна. (Асуулт Б3.а) Түүнчлэн, 10 хүүхэд тутмын 7 нь (74.2%) “баян байхыг шударга байхаас илүү зүйл, гэхдээ бүх юмыг мөнгөөр шийдэж болохгүй тул хааяа шударга байх хэрэгтэй” гэсэн санааг дэмжиж байна.

Баян байх нь амьдралын хамгийн чухал ололт бөгөөд баян болохын тулд худал хэлж, хууран мэхэлж, хууль зөрчиж болно гэж хариулсан хүүхдүүдийн хувь




Баян байх нь шударга байхаас чухал ч гэсэн бүх юмыг мөнгөөр хэмжиж болохгүй



ҮРГЭЛЖ ШУДАРГА БАЙЖ БОЛОХ УУ?


Нийт хүүхдүүдийн 10 хүүхэд тутмын 7 (72.1%) нь шударга байх хэрэгтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байгаа ч үргэлж юм бүхэнд шударгаар хандах боломж байхгүй гэж үзсэн байна. (Асуулт Б3.в.)

Шударга байх нь баян байхаас чухал ч гэсэн үргэлж шударга байх боломжгүй




Судалгаанд оролцогчдын 87.5% нь шударга байх нь амьдралын хамгийн чухал ололт бөгөөд баян байхаас илүү чухал гэж үзсэн хэдий ч үүнтэй бүрэн санал нийлж байгаа хүүхдүүдийн хувийг авч үзэхэд 6-р ангиас 10-р анги хүртэл 20%-иар буурч байна.

Шударга байх нь амьдралын хамгийн чухал ололт бөгөөд баян байхаас илүү чухал




Санал бүрэн нийлж байна.




ӨРХИЙН ОРЛОГОО НЭМЭГДҮҮЛЭХИЙН ТУЛД ХУУЛЬ ЗӨРЧИЖ БОЛОХ УУ?

Доорх үр дүнгүүдээс харахад хүүхдүүдийн ихэнх хувь нь эдгээр асуулттай санал нийлээгүй байгаа буюу өөрөөр хэлбэл өрхийн орлогоо нэмэгдүүлэх нь шударга байх, хууль сахихаас ямар нэгэн байдлаар илүүд тооцогдохгүй хэмээн хариулсан байна. Гэвч үүнийг хүлээн зөвшөөрсөн хүүхдүүдийн хувь 18.9 байгаа нь тэдгээр хүүхдүүд хууль зөрчиж өрхийн орлогоо нэмэгдүүлж болно хэмээн үзсэн байна. (Асуулт Б4.а, б, в, г.)


Өрхийн орлогоо нэмэгдүүлэх арга олох нь хамгийн чухал бөгөөд үүний тулд зарим хуулийг зөрчихөд зүгээр




Шударга байх, хууль журам сахих нь өрхийн орлогоо нэмэгдүүлэхээс илүү чухал



Өрхийн орлогоо нэмэгдүүлэх арга олох нь шударга байх, хууль сахиhaас арай чухал



Шударга байх, хууль журам сахих нь өрхийн орлогоо нэмэгдүүлэхээс арай чухал





Дээрх үзүүлэлтээс дүгнэхэд судалгаанд оролцсон хүүхдүүдийн 60%-иас илүү нь шударга байх нь өөрийн өрхийн орлогоо нэмэгдүүлэхээс чухал зүйл гэдэгт санал нийлж байгаа нь сайшаалтай байна.

ШУДАРГА ХҮН САЙХАН АМЬДАРДАГ УУ, ШУДАРГА БУС ҮЙЛДЭЛТЭЙ ХҮН САЙХАН АМЬДАРДАГ УУ?


Худал хэлдэг, хууран мэхэлдэг, хууль зөрчдөг, хахуулийг хүлээн зөвшөөрдөг хүмүүсээс шударга хүмүүс илүү амжилттай явах талтай байдаг гэж хүүхдүүдийн 50.8% нь үзсэн бол 44.0% нь үүнтэй санал нийлээгүй байна. Худал хэлдэг, хууран мэхэлдэг, хууль зөрчдөг, хахуулийг хүлээн

зөвшөөрдөг хүмүүс шударга хүмүүсээс илүү амжилттай явдаг гэдэгтэй анги өгсөх тусам (8-аас 10-р анги) санал нийлж байгаа бол “шударга хүмүүс илүү амжилттай явах талтай” гэсэн асуултанд анги багасах тусам л санал нийлж байна. (Асуулт Б5.)

Худал хэлдэг, хууран мэхэлдэг, хууль зөрчдөг, хахуулийг хүлээн зөвшөөрдөг хүмүүс бусад хүмүүсээс илүү амжилттай явах талтай байдаг



Үргэлж шударга ёсыг зарчмаа болгодог хүмүүс шударга ёсыг эрхэмлэдэггүй хүмүүсээс илүү амжилттай явах талтай байдаг



Суурь боловсролын агуулгын талаар 5.1.2-р зүйл: Гоо зүй, ёс суртахууны соёлтой, эрүүл чийрэг, иргэний үүргээ ухамсарласан, үнэнч шударга, хамтач, энэрэнгүй, эх оронч, хууль ёсыг дээдлэн сахидаг, үндэсний болон хүн төрөлхтний дэвшилт ёс заншил, соёлын үнэт зүйлсийг хүндлэн хайрладаг болгон төлөвшүүлэх

Боловсролын тухай хууль

“Зарим багш хүүхдүүдийг алагчилж муухай харьцдагийг би мэднэ. Би яаж үүнийг мэдэж байна вэ гэвэл би багш нарынхаа дунд нэр хүндтэй болохоор заримдаа яг адил зүйл хийсэн найз маань сахилгын шийтгэл хүртэж байхад намайг зүгээр өнгөрөөдөг, учир нь багш түүнд шударга бус ханддаг.”

Э, 10-р анги, эрэгтэй

СУРГУУЛЬ ТӨСВӨӨ НЭЭЛТТЭЙ БАЙЛГАХ ТАЛ ДЭЭР ШУДАРГА БАЙДАГ УУ?

Сургуулийн төсөвт ямар/хэр хэмжээний зардал тусгасан байдаг талаар чи хэр мэдэх вэ?



Сургуулийн төсвийн талаар мэдээлэлтэй байдаг эсэхийг асуухад мэдээлэлгүй-52.1%, маш бага мэдээлэлтэй-24.7%, тодорхой хэмжээний мэдээлэлтэй-14.9%, маш их мэдээлэлтэй-2.6% гэсэн нь хоёр хүүхэд тутмын нэг нь сургуулийн төсвийн талаар огт мэдээлэлгүй нь байдгийг харуулж байна. Нийт хүүхдийн 76.8% нь мэдээлэлгүй болон маш бага мэдээлэлтэй гэсэн нь цаашид сургуулийн төсвийг хэлэлцэхдээ хүүхдийн санал бодлыг сондог, оролцуулдаг байх механизм бий болгох шаардлагатайг харуулж байна. (Асуулт Б18.)



Сургууль ажиллахад зориулж улсаас ямар төсөв өгдгийг бид мэдэхгүй. Ямар ч гэсэн тоног төхөөрөмж, бичгийн хэрэгсэл, цэвэрлэгээний хэрэгсэл лав худалдан авах мөнгө, засварын мөнгө өгдөггүй юм шиг байгаа юм. Уг нь чанартай сайн засвар хийчихвэл дахин дахин засаад мөнгө хүүхдүүдээс татахгүй шүү дээ. Хэнээр засвар хийлгэж байгаа нь бас чухал. Бас сургууль эд зүйлээ гамтай хэрэглэх тал дээр хүүхэд багш, ажилтнууд бүгд чармайх хэрэгтэй шүү дээ.

С, 16 настай эмэгтэй

20 дугаар зүйл. Ерөнхий боловсролын сургуулийн захирлын нийтлэг эрх, үүрэг.2.4. зааснаар сургуулийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааг сургуулийн зөвлөл, багш, суралцагч, эцэг, эх, асран хамгаалагчийн оролцоотойгоор төлөвлөх, сургалтын орчныг бэхжүүлэх, төсөв, хөрөнгийг зориулалтын дагуу үр ашигтай зарцуулах, мэдээлэх үүрэгтэй байдаг.

Бага дунд боловсролын тухай хуулиас

8-р зүйл.1.2. Хүүхэд өөрт хамаарах аливаа асуудлаар шийдвэр гаргах, үнэлэлт өгөхөд оролцох эрхтэй байдаг.

Хүүхдийн эрхийн тухай хуулиас

Хөрөнгө, нөөцийн хувиарлалт бүлгийн 9b. Олон нийтийг, тухайлбал, хүүхдүүдийг төсвийн хэлэлцүүлэгт оролцуулах замаар болон төрийн албан хаагчдын хариуцлагыг нэмэгдүүлэх байдлаар төсвийн ил тод, оролцоот байдлыг хангахыг зөвлөж байна.

-НҮБ-ын Хүүхдийн Эрхийн Хорооноос Монгол Улсад өгсөн дүгнэлт, зөвлөмж

ШУДАРГА ЁСЫГ САХИХГҮЙ БАЙХ НЬ (АВЛИГА ӨГӨХ, АВАХ ЗЭРЭГ) ХЭНД АЮУЛТАЙ ВЭ?

Шударга ёсыг сахихгүй байх нь (авлига өгөх, авах зэрэг) Монгол улсын хөгжилд аюултай гэж хүүхдүүдийн 72% нь үзсэн бол тэдний амьдралд илүү ойрхон бодитой хүрээ буюу хүүхдүүд, гэр бүл ба найз нөхөд, бизнесийн үйл ажиллагаанд хортой гэж арав хүрэхгүй хувь нь үзсэн нь сонирхол татаж байлаа.



ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНҮҮДИЙГ ХҮҮХДҮҮД ХЭР ШУДАРГА ГЭЖ ҮЗЭЖ БАЙНА ВЭ?


Энэхүү асуултанд хүүхдүүд хувийн ААН, төрийн өмчит ААН, хувийн эрүүл мэндийн байгууллага, төрийн эрүүл мэндийн байгууллага, хувийн боловсролын байгууллага, төрийн боловсролын байгууллага, цагдаа, аюулгүй байдал хариуцсан байгууллага, орон нутгийн засаг захиргаа, нэгдсэн засаг захиргааг өөрсдийн бодлоор хэрхэн

шударга ажилладгийг нь үнэллээ. Хамгийн их авлига, буруу зан байдалтай газраар хүүхэд, томчуудтай шууд байдлаар харьцдаг нэгдсэн засаг захиргааг нийт судалгаанд оролцогчдын 15.1% маш муу хэмээн үнэлсэн бол цагдаа, аюулгүй байдал хариуцсан байгууллагуудыг 33% нь сайн гэж үнэлсэн байна. (Асуулт Б9.)

Хангалтгүй хэмээн үнэлсэн эрэмбэ



Эерэгээр үнэлсэн эрэмбэ




Улсын ЕБС-ийг хотын сурагчдын 11.2 хувь нь, хөдөө орон нутгийн сурагчдын 5.1% нь шударга бус гэж үзэж байгаа бол хувийн сургуулиудыг хотын сурагчдын 13.9 хувь нь, хөдөө орон нутгийн сурагчдын 7.6% нь шударга бус гэж үзсэн байна. (Асуулт Б9г, д.)

ЗАН БАЙДАЛД СУУРИЛСАН ШУДАРГА БАЙДАЛ

Шалгалтанд шударга хандах талаар асуухад хүүхдүүдийн 62.4% нь өөрийн хүчээр чадах бүхнээ хийнэ, найзаасаа тусламж гуйна гэсэн мөн тооны хүүхэд байна. (Асуулт Б10.)

Судалгаанд оролцогч хүүхдүүдийн 80.1% буюу арван хүүхэд тутмын найм нь худал гэж хариулсан нь хүүхдүүд шударга байдлыг эрхэмлэж өөрийн боломжинд тулгуурлан шалгалтыг өгөх хандлагатай байна. (Асуулт Б10 в.)

Бүх арга чаргаа ашиглана: хуулна, багш/туслахуудад нь бэлэг эсвэл мөнгө өгнө, материалаа урьдчилан авна



ШУДАРГА БУСААР БОЛОМЖ ОЛДОХ ҮЕД ХЭРХЭХ ВЭ?

Хамаатан чинь “манай сайн найз чамайг маш сайн сургуульд/их сургуульд/компанид шалгалтгүйгээр шууд оруулж чадна” гэвэл чи яах вэ?

Хүүхдүүдийн 50.2% нь энэ “боломжийг” хүлээн авна, 40.5% нь ийм зүйл хийхгүй гэжээ. Фокус бүлгийн ярилцлагаар хүүхдүүд гэр бүлдээ хүлээх үүрэг нь тэдний өөрийн үзэл бодлоос илүү давуу бөгөөд гэр бүлийнхнээ дэмжих нь байж болох хэвийн зүйл гэж үзсэн. (Асуулт Б11)



ЧИНИЙ БОДЛООР МОНГОЛ УЛСАД ШУДАРГА ЁСЫГ ЦОГЦЛОХОД ХҮҮХЭД, ЗАЛУУЧУУД ЯМАР ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭЖ ЧАДАХ ВЭ?


Нийт хүүхдүүдийн 72.6% нь шударга ёсыг цогцлоох, авлигатай тэмцэхэд хүүхэд, залуучууд их үүрэг гүйцэтгэж чадна гэж үзсэн байна. (Асуулт Б22)



Шударга бус байдлыг таслан зогсоохын тулд хамгийн түрүүнд ээж аавдаа, гэр бүлдээ, багшдаа худал хэлэхээ л больчих хэрэгтэй.

И, 12 настай эмэгтэй

Чиний бодлоор Монгол улсад шударга ёсыг цогцлооход хүүхэд, залуучууд ямар үүрэг гүйцэтгэж чадах вэ?



- Шударга ёсыг цогцлоох, авлигатай тэмцэхэд хүүхэд, залуучууд их үүрэг гүйцэтгэж чадна
- Шударга ёсыг цогцлоох, авлигатай тэмцэхэд хүүхэд, залуучууд багахан үүрэг гүйцэтгэж чадна
- Шударга ёсыг цогцлоох, авлигатай тэмцэхэд хүүхэд, залуучууд үүрэг гүйцэтгэж чадахгүй
- Хариулахад маш хэцүү асуулт байна

2

СУРГУУЛИЙН ОРЧИН ДАХЬ ШУДАРГА БУС БАЙДАЛ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧИЛ

ШУДАРГА БУС БАЙДАЛ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛИЙН ЭСРЭГ ШУДАРГА ЁСНЫ ЗАРЧМЫГ БАРИМТЛАХАД ТУЛГАРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

Багш, сургалтын менежерт бэлэг эсвэл мөнгө өгч байсан уу? гэсэн асуултанд тийм гэж хариулсан хүүхдүүд дараах шалтгааны улмаас өгсөн гэж хариуллаа.




ДҮҮГ НЬ ЦЭЦЭРЛЭГ, СУРГУУЛЬД ОРУУЛАХЫН ТУЛД МӨНГӨ БОЛОН ЭДИЙН ЗҮЙЛ ӨГЧ БАЙЖЭЭ:


Сургуулийн хүрэлцээнээс шалтгаалан хот, хөдөөд бэлэг эсвэл бэлэн мөнгө өгч байсан асуудал ялгаатай байна.

Хотын хүүхдүүдийн 31.6%, хөдөө орон нутгийн хүүхдүүдийн 13.5%-д энэ үйл явдал тохиолджээ.


Дүүг чинь цэцэрлэгт оруулахын тулд (тийм)



ТИЙМ



Сургууль цэцэрлэгт шилжүүлэхийн тулд багш, сургалтын менежерт бэлэг эсвэл мөнгө өгч байсан уу?



Үндсэн хуульд “Төрөөс бүх нийтийн ерөнхий боловсролыг төлбөргүй олгоно” гэж заасан боловч хотод амьдарч буй гурван хүүхэд тутмын нэг нь сургууль, цэцэрлэгт хамрагдахын тулд, хүүхдүүдийн 11.9% нь илүү чанартай сургууль руу шилжин суралцахын тулд авлига өгсөн байна. Чанартай боловсрол эзэмших эрхээ эдлэхийн тулд хандив, тусламж нэрийдлээр авлига өгөх явдлыг таслан зогсоож, нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, нийгмийн хямралаас хонжих явдлыг таслан зогсоох шаардлагатай байна.

Сургууль цэцэрлэгийг улсаас сайн тохижуулж өгөөсэй гэж хүсдэг. Яагаад гэвэл сургууль тохижуулна, анги тохижуулна гэж хүүхдүүдээс мөнгө хураадаг ба тэр мөнгө цуглуулж хийсэн зүйлс нь чанаргүй хурдан эвдрэх зүйлс байдаг.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Манай гэрийнхэн хөдөөнөөс ирсэн дүүг цэцэрлэгт оруулах гэж хөөцөлдсөн чинь ангид угаалгын машин хэрэгтэй байна, авч өгвөл оруулна гэсэн.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас.


Улсын шалгалт авах болоход хүүхдүүдээс 5000 төгрөг хураасан. Шалгалтын багш нарт идэх юм авч өгнө гэсэн. Энэ зөрчил биз дээ? Биднээс ийм мөнгө шаардаж байгаа нь хүртэл биднийг шалгалтаа өгөхдөө, дүгнүүлэхдээ багшаа хооллож авлига өгөхөд сургаж байна гэж бодож байна. Зарим хүүхдүүд онц сурдаг хүүхдэд мөнгө өгөх, хоол авч өгөх зэргээр шалгалтан дээр хуулдаг, даалгавраа хийлгэдэг болсон.


Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

САЙНААР ДҮГНҮҮЛЭХИЙН ТУЛД БАГШ, СУРГАЛТЫН МЕНЕЖЕРТ БЭЛЭГ ЭСВЭЛ МӨНГӨ ӨГЧ БАЙСАН УУ?

Судалгаанд оролцогчдын 93.6% нь үгүй гэсэн бол хотын хүүхдүүдийн 8.4%, орон нутгийн хүүхдүүдийн 2.2% нь сайн дүн авах, шалгалтандаа сайн оноо авахын тулд авлига өгч байсан гэж хариулжээ. Үүнээс үзэхэд сургуулийн орчин дах авлига хөдөө орон нутгаас илүүтэйгээр хотод явагдаж байна. Хүүхдүүдийг дүнгээр нь ялгаварлах, дүн тавихдаа шударга бус ханддаг тохиолдлууд гардаг нь энэхүү асуултаас харагдаж байна. Энэ нь тухайн хүүхдийн цаашдаа суралцах хүсэл эрмэлзэл, өөртөө итгэх итгэл, хичээл зүтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. (Асуулт Б6.в.)

Чамайг сайн дүн авхуулах эсвэл шалгалтандаа сайн оноо авахуулахын тулд






Зарим багш нар хүүхдүүдээс өөрт хэрэгтэй хичээлийн материалыг шаардаж авчруулаад 10 оноо өгнө гэдэг. Нэгдүгээрт энэ нь мөнгөн бус хахууль, хоёрдугаарт ийм байдлаар дүн нэмэх байсан юм бол хичээж хөдөлмөрлөсөн хүүхэд зүгээр суусан хүүхэд хоёрын хооронд ялгаа гарахгүй. Мөн хүүхдүүдэд багаас нь хахууль өгөхийг зааж байна. Зарим эцэг эхчүүд багш нарт нь бэлэг өгөх тусдаа уулзах замаар хүүхдүүдийнхээ дүнг нэмүүлдэг.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

БАГШ, ЭСВЭЛ СУРГАЛТЫН МЕНЕЖЕРИЙН ЗҮГЭЭС ЧАМД ХАНДАХ ХАРИЛЦААГ САЙЖРУУЛАХЫН ТУЛД БЭЛЭГ ЭСВЭЛ МӨНГӨ ӨГЧ БАЙСАН УУ?

Судалгаанд оролцогч хүүхдийн 93.6% нь “үгүй” гэж хариулсан бөгөөд 4.6% нь “тийм” гэж хариулсан нь тодорхой хэмжээгээр багш, сургалтын менежер бэлэг, мөнгө авдаг тохиолдол гардаг нь харагдаж байна. Фокус бүлгийн ярилцлагын үед хүүхдүүд “зарим багш нар хүүхдүүдтэй харилцахдаа ёс бус ханддаг, ялгаварладагаас шалтгаалан багш нарын хандлагыг өөрчлөхийн тулд бэлэг болон бэлэн мөнгө өгдөг” хэмээн өгүүлж байсан. Үүнээс үүдэн эцэг эхчүүд багш нарт авлига өгөх, хүүхэдтэй нь сайн хандуулах аргыг хайж эхэлдэг байна. Онц сурдаг, өөрийнхөө мэдлэгийн төлөө хичээдэг хүүхдүүд байхад, авлига өгөөд адилхан дүн авдаг хүүхдүүд ижил харьцуулагдаж байгаад хүүхдүүд их эмзэглэдэг хэмээн хэлж байсан. (Асуулт Б6.г)



Эрх мэдэлтэй, мөнгөтэй айлын хүүхдэд багш нар болон сургуулийн удирдлага сайнаар ханддаг нь нууц биш. Хичээж хичээж дүнгээ авсан хүүхэд юу ч хийхгүй байж авсан хүүхдийн дүн адилхан байдаг зэрэг нь шударга биш санагддаг.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

5.1.4. Иргэнийг сурч боловсроход үндэс угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, хөгжлийн онцлог, эрүүл мэнд, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодлоор нь ялгаварлан гадуурхахгүй байх, эх хэлээрээ сурч боловсрох тэгш боломж, нөхцөлөөр хангана гэж заасан.

Боловсролын тухай хуулиас



СУРГАЛТ, ТЭТГЭЛЭГТ ХӨТӨЛБӨРТ ХАМРУУЛАХЫН ТУЛД БАГШ, СУРГАЛТЫН МЕНЕЖЕРТЭЭ БЭЛЭГ ЭСВЭЛ МӨНГӨ ӨГЧ БАЙСАН УУ?

Тусгай сургалт тэтгэлэгт хамрагдахын тулд мөнгө, бэлэг өгдөг явдал 5-н хүүхэд тутмын 1 (18.3%)-д тохиолдож байжээ. Тусгай сургалт, тэтгэлэг гэдгийг судалгаанд оролцогчид тэмцээн, уралдаан гэдэг утгаар ойлгосон байж болох бөгөөд ЕБС-д зохион байгуулагдаж буй тэмцээн уралдааны шинж чанартай үйл ажиллагаануудын шударга байдалд хяналт тавих тогтолцоо хэрэгтэй гэдгийг харуулж байгаа юм. Нийт 18.3% нь тийм гэж хариулсан бол үүний 24.1% нь хотын хүүхдүүд, 14.2% нь хөдөө орон нутгийн хүүхдүүд байна.

Хичээлийн цагт заах ёстой хичээлээ цагтаа багтаан чанартай заагаагүй байж давлага өгөхөөр болоод хүүхдүүдээс мөнгө шаарддаг.


Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Чамайг тусгай сургалт, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахын тулд




АНГИ ДЭВШҮҮЛЖ БАЙГААД НЬ ТАЛАРХАЛ ИЛЭРХИЙЛЖ БАГШ, СУРГАЛТЫН МЕНЕЖЕРТ БЭЛЭГ ЭСВЭЛ МӨНГӨ ӨГЧ БАЙСАН УУ?

44.7% нь анги дэвшиж байгаадаа талархал илэрхийлж багш, сургалтын менежерт бэлэг эсвэл мөнгө өгч байсан байна. 6, 8, 10-р ангийн хүүхдүүдийн "тийм" гэж хариулсан дүнд нь харьцангуй ойролцоо байна.




Чамайг тусгай сургалт, тэтгэлэгт хөтөлбөрт хамруулахын тулд



2.2.4 “Сургууль, цэцэрлэг, албан бус, насан туршийн боловсролын төвийн багш, удирдах ажилтан, бусад ажилтан үйл ажиллагаандаа хүний эрх, эрх чөлөөг хүндэтгэх, хүнлэг энэрэнгүй, шударга ёсыг дээдлэх, ёс суртахууны үлгэр дуурайлалтай ажиллах, ялгаварлан гадуурхахгүй байж тэгш байдлыг хангах зарчмыг баримтална. Ажил үүргээ гүйцэтгэснийхээ төлөө сурагч, эцэг эхээс шан харамж, хээл хахууль авах өгөхөөс татгалзах, зуучлахгүй байх, төгсөлт, элсэлт зэрэг албан ёсны арга хэмжээ, баяр ёслолын үед үнэтэй бэлэг өгөхөөс аргагүй байдалд суралцагчид болон тэдний асран хамгаалагчид, эцэг эхийн зөвлөлийг хүргэхгүй байх, хуульд заасан төлбөр хураамж, хандив, хөрөнгийн зарцуулалттай холбоотой тайлан мэдээг цаг тухайд нь шударга, ил тод тайлагнадаг байх ёсзүйн хэм хэмжээг дагаж мөрдөнө”


Багшийн ёс зүйн дүрмээс

ХАХУУЛЬ ӨГӨХ ЭСЭХ ДЭЭР ХҮҮХДИЙН ҮЗЭЛ БОДОЛ




Хүүхдүүдийн гуравны хоёр нь авлигыг шударга бус зүйл гэж үздэг бөгөөд гэр бүл нь ийм үйлдэл хийхгүй гэжээ. Хүн бүр л авлига өгдөг юм чинь гэж үзсэн охидын хувьд 5.2%-иар илүү байна. Авлигыг шударга бус зүйл гэж үзсэн 10-р ангийн сурагчдын хувь өндөр байна. (Асуулт В7в, г)

Хүүхдүүдийн 38.5 хувь нь хээл хахууль бол хэрэгцээ шаардлага, гэр бүл нь өгөх бололцоотой гэж хариулсан бол 16.9 хувь нь хээл хахууль өгөх шаардлага гарсан ч гэр бүл нь өгөх бололцоогүй гэж үзсэн байна. (Асуулт В7 а.б.)



ГЭРИЙНХЭН ЧИНЬ ХАХУУЛЬ ӨГӨХ БОЛОМЖГҮЙ УЧРААС ЧАМД ТААГҮЙ ХАНДАЖ БАЙСАН УУ?

Хүүхдүүдээс мөнгө хураах нь өгч чадаагүй, боломжгүй айлын хүүхдүүдийн хувьд дарамт болж байна. Үе тэнгийнхнээсээ ичих, цаашлаад гэр бүлийнхээ амьдралын түвшинд сэтгэлээр унах зэрэг олон асуудал тулгардаг. Энэ нь хүүхдүүдийн хувьд суралцах хүсэл эрмэлзлэл, хүсэлд сөргөөр нөлөөлж байна. Нийт судалгаанд оролцогч хүүхдүүдийн 6.1%-д нь таагүй хандах асуудал тулгарч байсан ба энэ нь анги дэвших тусам нэмэгдсэн байна.





Гэрийнхэн чинь хахууль өгөх боломжгүй учраас чамд багш таагүй хандаж байсан уу?



Судалгаанд оролцсон хүүхдүүдийн 12.3% нь гэр бүл нь зарчмын хувьд авлига өгөхөөс татгалзсаны улмаас ийм хандлагыг мэдэрч байжээ. (Асуулт 8)

Гэрийнхэн чинь хахууль өгөхийг буруу гэж үзэн татгалзсан учраас чамд багш таагүй хандаж байсан



БАГШ ЧИНЬ ХИЧЭЭЛД ЧИНЬ ХАМААРАЛГҮЙ НОМ/ЗАХИАЛГЫН СОНИН СЭТГҮҮЛ/ ТАСАЛБАР/БУСАД ЭД ЗҮЙЛС ЗАРАХ БУЮУ ЗАХИАЛУУЛБАЛ ЧИ ЯАХ ВЭ?



Эцэг, эхтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзэхэд хүүхдүүдийн хувьд багш мөнгө нэхсэн үед хэцүү ч гэсэн аль болох авчрахыг хичээдэг байна. Сүүлийн үед багш нар энэ ажлын ард

нуугдаж эцэг эхчүүдийн зөвлөлөөр дамжуулан мөнгө, хандив цуглуулдаг болсон байна. (Асуулт Б12)




АНГИЙН ДАРГЫН СОНГУУЛИЙН ТАЛААРХ ХҮҮХДҮҮДИЙН БОДОЛ

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас үзэхэд ангийн даргаа сонгохдоо хуучин бол багшийн дуртай сурагчийг сонгодог байсан бол одоо хүүхдүүд өөрсдөө сонгох боломжтой, хүссэн хүүхэд нэрээ дэвшүүлэх боломжтой илүү ардчилсан болсон байна. Гэхдээ арга зүйн хувьд томчуудын зүгээс дэмжлэг, чиглүүлэг байх шаардлагатай байна.

3-р ангийн сурагч ангийн даргын сонгуульд ялахын тулд ангийнхандаа 1000 төгрөг тараасан тухай энэ үеэр нийгмийн сүлжээнд мэдээлэгдэж байлаа.

Дээрэлхүүлж, гутаагдан доромжлогдсон байдал Энэ улиралд юм уу өмнөх улиралд чамд, дээрэлхүүлсэн эсвэл доромжлуулсан юм шиг санагдсан эсэхийг асуухад 10 хүүхэд тутмын 7 (69.5%) нь ямар нэг байдлаар дээрэлхүүлж, доромжлуулсан байна. 6-р ангийн хүүхдүүдийн 78.3% нь тийм гэж хариулсан бол 10-р ангийн хүүхдүүдийн 65.4% тийм гэжээ. Энэ асуултын хариу охид, хөвгүүд, хот, хөдөөд төдийлөн ялгаатай гарсангүй. (Асуулт Б14)



Тийм гэж хариулсан хүүхдүүд хэн тэднийг дээрэлхэж, гутаан доромжилсон талаарх мэдээллийг өгсөн юм. (Асуулт Б14)

Доромжлох, дээрэлхэх асуудал бүр дасал болсон зүйл. Дээд ангийн хүүхдүүд доод ангийнхныг үг хэлээр доромжлох зүйлс хэвийн мэт болсон. Сурч байгаагаар сургуулиар нь доромжилдог. Манай сургуулийг гэр хорооллын сургууль гэх мэтээр доромжилдог. Ангиар нь гадуурхдаг. Танай анги угаасаа муу гэх мэтээр ялгаварладаг.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас



Хүүхдүүд дунд үе тэнгийн дарамт их байдаг. Ялангуяа нэгэндээ хоч өгөх, үг хэлээр доромжлох тохиолдол их байдаг. Ангийн багшдаа хэлэхэд нэг удаадаа л арга хэмжээ аваад л өнгөрнө. Зарим багш нар бүр тоодог ч үгүй. Сургалтын менежерт хэлэхээр ямар ч арга хэмжээ авдаггүй ба хүүхдүүд өөрсдөө л энэ асуудалтай нүүр тулахаас өөр гарцгүй болдог. Эцэг эхдээ хэлэх гэхээр ангид болсон зүйл ангидаа л өнгөрөх ёстой гэх ба эцэг эх багш нар хоорондоо тулж ажиллаж байгаа юм байдаггүй. Багш, менежерт хэлээд нэмэр байхгүй учраас бид чимээгүй л өнгөрдөг. Гэтэл бид чинь хүүхдүүд шүү дээ. Аливаа асуудлыг хэрхэн шийдэхээ мэдэхгүй, үе тэнгийнхэндээ дарамтлуулаад яваад байх нь бидний зан чанар сэтгэл санаанд муугаар нөлөөлдөг.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Зарим эцэг эхчүүд багшийг хүүхдийн сурлагын чанарт анхаар гэдэг, нөгөө нь хүмүүжил, ёс зүйд нь анхаар гэж зэмлэдэг. Багш нь хүүхдийг чинь сургаж хүмүүжүүлэх гээд анхаарахаар эцэг эх нь юуг ч ойлгоогүй байж, багштай ярилцаагүй байж, багшийг буруутгадаг, бүр цалинг нь хасуулдаг тал байдаг болохоор олонх багш нар зөвхөн цагийнхаа хичээлийг заагаад гаръя, “илүү зүйл”-д анхаараад яах вэ гэж үзэх нь олширсон. Бас нөгөө талаар сурган хүмүүжүүлэх аргагүй муутай, хүүхэдтэй харилцах ёс зүйн асуудалтай зарим багшаас болж багшийн нэр хүнд унаж байна. Хүүхдийг шударга, боловсролтой хүн болгохын тулд хүмүүжлийн үлгэрлэсэн, хүчирхийллийн бус аргыг эцэг эх та бүхэнтэй хамтран хамтдаа хэрэглэх цаг болсон байна.

Багш нартай хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

- 1236 сурагчийн 13.1 % нь гэрийнхэн нь мөнгөөр гачигдаж байгаад санаа нь зовж байна гэж хариулжээ.
- Гэртээ аюулгүй тайван байж чаддаг эсэхийг асуухад 3.6 хувь нь гэртээ айдастай байдаг тухайгаа өгүүлсэн байна.
- Өнгөрөгч онд хүүхдүүдийн 81.2 хувь нь ямар нэг зүйлд зориулан сургуульдаа мөнгө хураалгасан.
- Гурван хүүхэд тутмын нэг нь боловсрол, сургуультай холбоотой асуудлаар санал бодлоо илэрхийлж, нөлөөлөх хүсэлтэй байв.
- 37.9% нь өнгөрөгч онд дээрэлхүүлж, гутаагдан доромжлогдсон байна
- 84.2% нь дээрэлхүүлж, гутаагдан доромжлогдвол хэнд хаана хэрхэн хандахаа мэдэхгүй гэжээ.

“Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгаа, 2017

ДЭЭРЭЛХҮҮЛСЭН, ДОРМЖЛУУЛСАН БОЛ ЭНЭ НЬ ЮУНААС БОЛСОН БАЙХ ГЭЖ БОДОЖ БАЙНА ВЭ?



Эхний “Өсвөр үеийнхний дуу хоолой” судалгааны дараа дээрэлхүүлж, гутаагдан доромжлогдохын шалтгааныг тодруулахыг хүссэн бөгөөд энэ удаа үе тэнгийнхний зүгээс тэдэнд учруулж буй

дарамт нь хурц шүүмжлэл, өөртөө нийцүүлж өө хайн шүүмжлэх явдал хэмээн фокус бүлгийн ярилцлагаар тодотгосон юм.

3

ШУДАРГА БУС БАЙДАЛ, АВЛИГА, АШИГ СОНИРХЛЫН
ЗӨРЧИЛТЭЙ ТЭМЦЭХ ХҮСЭЛ ЗОРИГ


АВЛИГАТАЙ ХОЛБОГДОХ ҮЙЛДЭЛТЭЙ ТУЛГАРСАН БОЛ ЭНЭ ТАЛААР МЭДЭЭЛЭХ ҮҮ?

Нийт судалгаанд оролцогч 10 хүүхэд тутмын 1 (14.3%) нь ямар нэгэн авлигатай холбогдох үйлдэл тулгарахад мэдээлэхгүй гэсэн бол мөн

10 хүүхэд тутмын 3 (31.4%) нь нөхцөл байдлаас шалтгаалан мэдээлнэ гэж хариулжээ. (Асуулт Б15.)



Тухайн нөхцөл байдлаас шалтгаалан сурагчдын мэдээлэх хүсэл зоригийн хэмжээ 10-р ангийн сурагчдад 39.2%, 6-р ангийн сурагчдад 21.7% - ийн тоон үзүүлэлттэй байгаагаас үзэхэд анги ахих тусам тэдний зөрчил болон үр дагаварын мэдрэмж өссөн болохыг харуулж байна.


ХЭРЭВ АВЛИГАТАЙ ХОЛБООТОЙ ҮЙЛДЛИЙГ МЭДЭЭЛЭХЭД БЭЛЭН БИШ БАЙГАА
БОЛ ЯАГААД ВЭ?

Дээрх асуултанд нийт судалгаанд оролцогчдын 51.1% нь л хариулсан бөгөөд тэдгээрийн 9.9% нь мэдээлсэн ч хүүхдийг хамгаалах тогтолцоо байхгүйгээс асуудлыг мэдээлэхээс айсан, 18.3% нь “Мэдээллээ гээд ямар ч нэмэргүй” гэж үзэж байсан бол 14% нь өөрийгөө хэрхэн илэрхийлэхээ мэдэхгүй, 8.9% нь өөр дээрээ

ямар нэгэн байдлаар бусдын анхаарлыг татахыг хүсээгүй хэмээн хариулжээ. (Асуулт Б16.)


Судалгааны үр дүнгээс үзэхэд, хүүхдүүдэд мэдээлэх арга замын талаар мэдлэг мэдээлэл хомс байна.

Хэрэв авлигатай холбоотой үйлдлийг мэдээлэхэд бэлэн биш байгаа бол яагаад?



- Алгассан
- Намайг хамгаалахгүй учраас би мэдээлэхээс айж байна
- Би мэдээллээ гээд ямар ч нэмэргүй (арга хэмжээ авахгүй) гэж бодож байна
- Яаж мэдээлэхээ мэдэхгүй байна
- Би анхаарал татмааргүй байгаа учраас хэнд ч мэдээлэхийг хүсэхгүй байна
- Хариулахад маш хэцүү асуулт байна

Намайг хамгаалахгүй учраас би мэдээлэхээс айж байна



Хүүхдүүдийн 86% нь шийдвэр гаргагчид тэдний дуу хоолой, санал бодлыг сонсох нь нэн чухал гэж үзэж байгаа хэдий ч 87,4% нь шийдвэр гаргагчдад өөрсдийн үзэл бодлоо илэрхийлэх боломж хомс буюу боломжгүй гэж үзжээ.

Өсвөрийн дуу хоолой 1 судалгаа, 2017

4

ШУДАРГА БАЙДАЛ БА ОРЧНЫ НӨЛӨӨ

Хүүхэд шударга ёсыг сахих хэрэгтэйг илэрхийлсэн дүрэм журмын талаарх мэдээ мэдээллийг авч, шударга байдлын талаар үзэл бодлоо төлөвшүүлэн үлгэр жишээ авахад гэр бүл, сургууль, найз нөхөд буюу хамгийн их хамт цагийг өнгөрөөдөг хүмүүс нь илүү өндөр үүрэг гүйцэтгэж байгааг харж байна. Гэвч судалгааны зарим үр дүн нь сөрөг байгаагаас авч үзвэл гэр бүл, сургуулийн орчин шударга байдлын талаарх мэдээ мэдээллийг зүй зохистой мэдээлэхэд илүү их анхаарах хэрэгтэйг харж байна.

Боловсролоор дамжуулан хүн нийгмийн ёс зүйтэй гишүүн болох учиртай. Ёс зүй нь насан туршийн биеэ авч явах байдлын хэм хэмжээг агуулдаг. Ёс зүйгээр үлгэрлэж сургах учиртай хүмүүс бол багш, эцэг эх. Гэтэл эдгээр хүмүүс яг ямар ёс зүйг үлгэрлэж байна вэ? Боловсролтой, болж буй үйл явдлын талаар ухаалаг үнэлэлт, дүгнэлт өгч чаддаг, ёс зүйтэй, тууштай, хичээнгүй хүн болохыг нь дэмжмээр байгаа юм. Хүүхдийн сэтгэлгээний цар хүрээнд хязгаарлалт тавьж, урам зоригийг мохоох, өөртөө итгэлтэй байдал, амьдралд итгэх, хүмүүст итгэх байдлыг үгүй хийх эрх хэнд ч байхгүй.

Эцэг эхчүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

Авлигын талаар мэдээлэл хүүхдүүдэд хомс байдаг. Хүүхдүүд багаасаа авлигын эргэн тойронд өсч өндийж байна. Бие даах ажил гэдэг зүйлийг яаж хийхийг зааж өгдөггүй. Бие даалт багш нар маш их өгдөг. Хүүхэд, бие даах ажил гэж юу байдгийг оюутан ах эгчээсээ сураад хийчихдэг хүүхдэд авлига өгч бие даах ажлаа хийлгэдэг тохиолдол зөндөө. Заавал мөнгөөр хэвлүүлэх, компьютер ашиглах бие даалтууд байдаг. Гэтэл бидэнд мөнгөний боломжгүй үе зөндөө байдаг.

Хүүхдүүдтэй хийсэн фокус бүлгийн ярилцлагаас

АВЛИГААС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ДҮРЭМ ЖУРМЫН ТАЛААР ХҮҮХЭД ХЭР МЭДДЭГ ВЭ?

Хүүхдүүдийн 46.1% нь авилгаас урьдчилан сэргийлэх, зарчимч шударга байдлыг дэмжих хууль журмын талаар мэдээлэлгүй, тун багахан мэдээлэлтэйгээ илэрхийлсэн ба 47.1% тодорхой хэмжээнд мэдээлэлтэй гэсэн байна. Судалгааны үр дүнг мэдээлэлтэй байдлын хувьд харьцуулбал 10-р ангийнхан 55%-тай байгаа бол 6-р ангийнхан 43.2% -тай байгааг харж болно. (Асуулт Б17.)




Манай багш хүүхэд болгонтой ижилхэн харьцдаг. Миний ээж, аав гэр бүлийнхэн нэг ч удаа хахууль өгч байгаагүй. Найз нөхөд маань бусдыг муулж гомдоодоггүй сайн хүүхдүүд байдаг.

Л, 12 настай эмэгтэй

ШУДАРГА БАЙДЛЫН ТАЛААР ХҮҮХДИЙН ҮЗЭЛ БОДОЛ ТӨЛӨВШИХӨД НӨЛӨӨЛДӨГ ТАЛУУД

Гэр бүл, сургууль, хэвлэл мэдээлэл хүүхдийн шударга байдал, зарчимч чанар, ашиг сонирхлын зөрчлийн эсрэг талаар үзэл бодлоо төлөвшүүлэхэд нөлөөлж байна. Хүүхдийн чанартай чанартай боловсролыг тэгш,

хүртээмжтэй эзэмших эрхийг хангахын тулд бүх талууд хамтран ажиллах хэрэгцээ шаардлага байгааг онцлон тэмдэглэж байна. (Асуулт Б19, Б20, Б21)



ХАВСРАЛТ

ҮР ДҮН, Хүснэгтээр

1. Судлуулагчдын хүйс (нийт, Монгол)

№	Хүйс	Хувиар	Давтамж
1	Эрэгтэй	48.1%	1054
2	Эмэгтэй	51.9%	1137
Нийт		100.0%	2191

2. Анги (нийт, Монгол)

№	Анги	Давтамж	Хувиар
1	6	663	30.3%
2	8	730	33.3%
3	10	798	36.4%
Нийт		2191	100.0%

3. Байршил (нийт, Монгол)

№	Байршил	Давтамж	Хувиар
1	Хот	920	42.0
2	Хөдөө	1271	58.0
Нийт		2191	100.0

Үзэл хандлага

Б1 Чиний хувьд шударга хүн хэнийг хэлэх бэ?

№	Хариулт	Хүйс		Анги			Байршил		Нийт
		эр	эм	6-р анги	8-р анги	10-р анги	хот	хөдөө	
1	Хэзээ ч худал хэлж, хууран мэхэлдэггүй, тиймээс ч итгэж болох хүн	48.0%	51.2%	48.3%	47.7%	52.6%	50.5%	49.0%	49.7%
2	Зардал хэмнэх, гэр бүлийнхээ хэцүү хүнд байдалд оруулахаас бусад тохиолдолд худал хэлж, хууран мэхэлдэггүй хүн	7.2%	8.5%	8.3%	8.8%	6.8%	8.7%	7.3%	7.9%
3	Ямар ч нөхцөл байдалд хууль зөрчдөггүй хүн (төрийн хууль журмыг мөрддөг)	15.3%	16.8%	13.4%	16.8%	17.5%	13.0%	18.3%	16.1%

4	Хууль зөрчсөн байлаа ч гэр бүл, найз нөхдийнхөө талд байдаг	7.6%	5.5%	10.7%	6.4%	3.1%	9.2%	4.6%	6.5%
5	Ямар ч нөхцөлдп хахууль авч, өгдөггүй хүн	10.0%	9.4%	9.8%	9.6%	9.6%	7.1%	11.6%	9.7%
6	Жижиг бэлэг, багахан хэмжээний мөнгө биш л бол хахуулиас татгалздаг хүн	1.7%	1.1%	1.8%	1.1%	1.3%	1.4%	1.3%	1.4%
7	Хүн бүр хахууль өгч, аваагүй л бол асуудал шийдэхдээ үүнээс татгалздаг хүн	1.9%	0.7%	1.1%	1.1%	1.6%	1.0%	1.5%	1.3%
8	Хариулахад маш хэцүү асуулт байна.	8.3%	6.8%	6.6%	8.5%	7.4%	9.0%	6.5%	7.5%
	Нийт	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%	100.0%

Мэдээлэлтэй байдал

